

ХОЁР. 2020 ОНЫ ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТОВЧ ТАЙЛАН

КОМПАНИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Ерөнхий мэдээлэл

Компанийн оноосон нэр	"Улаанбаатар БҮК" ХК
Үүсгэн байгуулагдсан огноо	1996-04-27
Албан ёсны хаяг	Баянгол дүүрэг, 20-р хороо, "УБ БҮК" ХК-ийн байр
Шуудангийн код	18031
Ажилчдын тоо /2020 дундаж /	257
Дүрмийн сан	131'547'500 төгрөг
Гаргасан хувьцаа ^а нэрлэсэн үнэ	131'547'500 ширхэг ^а 1 төгрөг
Улсын бүртгэлийн дугаар	9010001027
Регистрийн дугаар	2041219
Компанийн дүрэм: ХЭХ шийдвэр огноо, №	2017 он 04 сар 26 өдөр, №2017/06
Утас:	976-70001182
Факс:	976-70001713
Вэб сайт:	http://www.ubbuk.mn
И-мэйл:	info@ubbuk.mn

Үйл ажиллагаандаа шинэ техник, технологи нэвтрүүдсэн байдал

2020 онд шинэ бетон зуурмагийн уэль /БАЗ-4/ болон төмөр замын дэр бетон үйлдвэрлэх нэмэлт хоёр шугамыг өөрсдийн хүчин чадал, нөөц бололцоонд тулгуурлан суурьлуулж ашиглалтад оруулсан. Ингэснээр төмөр замын дэр бетон үйлдвэрлэх хүчин чадал нь хоногт 1600-1800 ширхэг болж нэмэгдсэн.

Бүтээгдэхүүний багцын танилцуулга

Дор жагсаасан үндсэн 3 нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл эрхэлдэг.

Жилийн хүчин чадал:

1. ТБХЭ: **30000 м3**
2. Төмөр замын төмөр бетон дэр: **420000-576000 ширхэг**
3. Метал хийц: **3600 тонн**

ТБХЭ-ийн хувьд тус компани төрөл бүрийн стандарт бүтээгдэхүүнээс гадна өгөгдсөн хийц загвар, хэмжээс бүхий стандарт бус төмөр бетон хийц эдгэлийг зураг төслийн дагуу чанарын түвшинд үйлдвэрлэдэг.

ХОЁР. 2020 ОНЫ ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТОВЧ ТАЙЛАН

Үйл ажиллагааны тойм

Тайлант оны гол ололт амжилтууд

Бизнесийн стратеги ба менежмент

- 2020 оны бизнес төлөвлөгөө, стратегийг хэрэгжүүлэх хүрээнд 2020 онд алба/ нэгж бүр үйл ажиллагаагаа төлөвлөн тайлагнаж ажилласан.
- Дараахь үйл ажиллагааны стандарт горныг холбогдох техник технологийн, мэргэжлийн шаардлага, нийтлэг жишигт нийцүүлэх алхмууд хийсэн:
 - Үйлдвэрлэлийн технологийн заавар журам, карт, ажлын зааварчилгаа:
 - БА3-3, БА3-4 бетон зуурмагийн үйлдвэрүүд
 - “RMS” технологийн шугамын төмөр бетон дэрний үйлдвэр
 - Дулааны сувгийн тэвш /лотки/, авто замын хашлага, хашаа
 - “Тенсиланд” технологийн шугам
 - “Вольтамикс” технологийн шугам
 - Борлуулалт, худалдан авалт, агуулах, чанарын хяналт шалгалт, ЖАБЭА
 - Бараа материалын хяналтын систем, цалингийн систем

Маркетинг Борлуулалт

- Борлуулалт маркетингийн судалгаанууд хийж танилцуулсан
- Харилцагчийн удирдлагын систем /CRM/ нэвтрүүлсэн
- МТЗ ТӨХК-тай ТЗТБД нийлүүлэх үндсэн болон нэмэлт гэрээнүүд байгуулж, борлуулалтыг амжилттай зохион байгуулсан

Худалдан авах ажыллагаа

- Дотоод гадаадын татан авалтыг гэрээ хэлэлцээрийн дагуу компанид давуу байхуйц чанарын түвшинд хийж гүйцэтгэсэн
- Үйлдвэрт шаардлагатай бүх сэлбэг тоног төхөөрөмжийг цаг хугацаанд нь хангаж тасралтгүй ажыллагааны нөхцлийг хангасан
- БА3-4-н тоног төхөөрөмжийн импорттой холбоотой гааль тээврийг хийж заавар, танилцуулга, гаалийн бүрдүүлэлтийн хятад болон англи хэлний орчуулгыг хийсэн
- Бэлтгэн нийлүүлэгчийн судалгаа хийж мэдээллийн сан бүрдүүлсэн

Хүний нөөцийн чадавхийг бүрдүүлэх, хөгжүүлэх:

- Ажилчдын сэтгэл ханамжийн түвшин 80%
- УББҮК ХК-ийн дэргэдэх сургалтын төвд нийт 5 ажилтан сургаж “Гүүрэн кранчин” мэргэжил олгосон ба GIZ төслийн хүрээнд үйлдвэрлэлийн дадлагажуулагч багшаар 4 ажилтан сургасан.

ХОЁР. 2020 ОНЫ ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТОВЧ ТАЙЛАН

Цахилгаан дулаан хангамж

- Үйлдвэрт 3 дэд өртөө /КТП/ суурилагдсан байх байсны 2 нь сууриалгадсан, нэг нь тоногдсон байсныг бүрэн шинэчилж 3 дэд өртөөг ажилд оруулсан. Зөвхөн нэг өртөөн дээр ихэнхи ачаалал хуваарилагдсан байсныг өөрчилж 3 дэд өртөөн дээр тэнцүү хуваарилсан. Аль нэг дэд өртөөнд засвар хийх шаардлага гарсан үед нөгөө дэд өртөө рүүгээ сэлгэн залгалт хийх боломж бүрдүүлсэн. Эдгээрийг хийхэд доорхи ажлуудыг хийж гүйцэтгэлээ.
- Цахилгааны дэд өртөө /КТП/-г бүрэн сэргээж өндөр хүчдэлийн кабель шинээр татан трансформатор /1кВт/ суулган хуучин тоноглолыг сэлбэн засварлах замаар үйлдвэрийн цахилгаан хангамжийн доголдлыг шийдэж, ачаалал бууруулсан
- Гадна талбайн гүүрэн краны ерөнхий тэжээлийн кабелийг КТП-2 –оос шинээр татсан, КТП-2 доторх хуучин ТМ-1000 маркын трансформатор болон тоног төхөөрөмжийг сэргээн засварласан
- Шинээр КТП-4 угсран ажиллуулж эхэлсэн
Дээрээс борооны ус зайлуулах шугамууд бөглөрсөн байсныг засч бөглөөг гаргав.
- Гадна дотно борооны ус зайлуулах шугамыг сэргээсэн
- Хүйтэн ус нөөцлөх запас 25 тонны багтаамжтай ёмкость суурилуулж, үйлдвэр тойруулан усан хангамжийн шугам татан бусад объектуудтай холбох замаар бүрэн автомат горимд шилжүүлсэнээр бетон узель ажиллах үед усны даралт унах асуудлыг шийдсэн.
- Үйлдвэрийн бойлуур, насос, холбох хэрэгслийн засварын ажил хийсэн
- Оффисийн барилгын халаалт аваагүй хэсгүүдэд халаалт, сантехникийн хэрэгсэл суурилуулж угсарсан

Барилга угсралтын ажлууд:

- БАЗ-4-ийн барилгын зураг төсөл, угсралт болон дээрний ажил (203 м.кв) хийж гүйцэтгэсэнээр бетон зуурмагийн үйлдвэрлэлийн хүчин чадал 2 дахин өсөв.
- Механик цехийг өргөтгөх зорилгоор гаражийн байр /1404 м.кв/ засвар хийж тохижуулав.
- Үйлдвэрт ашиглагддаггүй байсан 216 кв.м талбайг засвар хийн тохижуулж цахилгааны хэсгийн байр болгов.
- Том силосийн дээвэр (115 кв. М.) засварлав. Вагоноос том силос руу цемент шууд буулгах, том силосоос жижиг силос руу цемент шууд татах, вагоноос жижиг силос руу цемент шууд татах төхөөрөмж угсарч байна.
- ТБХЭ цехийн 3-р пролетод ИТА-д зориулсан ажлын байрыг засварлав.
- Хоолны заал томсгох 110 метр квадрат талбайн барилга угсралтын ажил
- 432 м2 биеийн тамирын зориулалттай танхимын барилгын ажил

ХОЁР. 2020 ОНЫ ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТОВЧ ТАЙЛАН

- Компанийн баруун хаалганы засварын ажил
- Ажилчдыг ковид-19 өвчний карантинийн үед байрлаж ажиллуулах зорилгоор 1-р давхарын ашиглагддаггүй байсан байр талбайг засварласан.

2020 оны зорилтуудын биелэлт

Компани нь 2020 оны бизнес төлөвлөгөөгөөр нийт 18 зорилт болон 59 шалгуур үзүүлэлт (тоо хэмжээ, чанар, хугацаа болон өртөг) төлөвлөсөн бөгөөд гүйцэтгэл 72 хувийн биелэлттэй байна.

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ БА КОМПАНИЙН ХУВЬЦАА

Хувьцааны мэдээлэл, 2020.12.31-ны байдлаар

Өмнөх өдрийн хаалт	430.72
Нээлтийн ханш:	0
Хаалтын ханш:	430.72
Тухайн өдрийн VWAP	0
Авах дээд үнэ:	401.01 x 70
Зарах доод үнэ:	440.00 x 3,000
Нийт хувьцааны тоо ширхэг:	131,547,500
Гаргасан хувьцааны тоо ширхэг:	131,547,500
Арилжигдсан ширхэг:	0
Арилжааны үнийн дүн:	0
Хэлцлийн тоо:	0
52 долоо хоног:	300.00 - 458.00
Зах зээлийн үнэлгээ:	56,660,139,200.00
ISIN:	MN00BUK01956

Хувьцаа эзэмшигч ба ногдол ашгийн хуваарилалтын мэдээ

Нэлээ бүхий хувьцаа эзэмшигч	Тус компанийн хувьцааг эзэмшиж буй байдал		Бусад компанийн хувьцааг эзэмшиж буй байдал		
	Хувьцааны тоо ширхэг	Нийт хувьцаанд эзлэх хувь	Компанийн нэр	Хувьцааны тоо ширхэг	Нийт хувьцаанд эзлэх хувь
"Улаанбаатар менежмент" ХХК	128,315,700ш	97.5%	Бусад	3,231,800 ш	2.5%

ХОЁР. 2020 ОНЫ ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТОВЧ ТАЙЛАН

	Хувьцааны тос	Нэгж хувьцаанд зарласан ногдол ашиг /төг/	Нийт ногдол ашиг /сая төг/	ТУЗ-ийн тогтоол №
2019 он	131,547,500	4	526.2	2020 оны 2-р сарын 17-ны өдрийн № 2020/01
2020 он	131,547,500	30	3,946.4	2021 оны 2-р сарын 09-ний өдрийн №2021/02